



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.03.16

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.03.16 № 2/146
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Г “ЧАНДМАНЬ- БАЯНХОНГОР”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.СОРОНЗОНБААТАР ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Чандмань-Баянхонгор” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Чандмань-Баянхонгор” ХК-ийг өөрчлөн байгуулж, дүрмийг батлах тухай” 5/03 дугаар тогтоолоор “Чандмань Баянхонгор” ХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050215
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. ад-
албан тоот.docx

Байгууллагын хөрөнгийн түргэн хөрвөх чадвар жил бүр буурч байгаа тул мөнгөн урсгалыг сайжруулж, авлагыг удирдлагыг дээшлүүлж, зардлын өсөлтийг бууруулж хянах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 88.3 хувиар үнэлсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 60 жилийн ой тохиож байгууллагын албан хаагчид, иргэн, аж ахуй нэгжээс 19,727.4 төгрөгийн хандив авч байгууллагын номны үнэнд 2,210.0 мянга, хүлээн авалтын зардалд 16,490.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2024 он	2025 он
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	239,474,505.97	113,095,484.22
1.1.2	Дансны авлага	150,476,672.58	349,703,238.16
1.1.7	Бараа материал	232,600,073.54	271,748,078.95
1.1.8	Урьдчилж гарсан зардал	200,555,711.56	200,555,711.54
1.1.2	Эргэлтийн хөрөнгийн дүн	823,106,963.65	935,102,512.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,902,556,121.28	4,237,367,921.73
1.2.7	Биет бус хөрөнгө	610,203,246.88	605,552,010.86
1.2.2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,512,759,368.16	4,842,919,932.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,335,866,331.81	5,778,022,445.46
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		86,475,906.77
2.1.1.3	Татвар-ын өглөг	9,725,787.71	70,795,038.81
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.2	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,725,787.71	157,270,945.58
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	84,361,356.67	
2.1.2.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	66,780,510.98	-
2.1.2.2	Өр төлбөрийн нийт дүн	76,506,298.69	157,270,945.58
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.2.1	Өмч : а) төрийн	313,835,027.38	313,835,027.38
2.2.2	б) хувийн	78,458,800.00	78,458,800.00
2.2.4	Хувьцаат капиталын дүн	392,293,827.38	392,293,827.38
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	609,365,573.82	609,365,573.82
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	4,299,021,544.69	4,299,021,544.69
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(41,320,912.77)	320,070,553.99
2.2.2	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,259,360,033.12	5,620,751,499.88
2.3.2	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	5,335,866,331.81	5,778,022,445.46

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 он	2025 он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	3,310,059,045.62	4,096,668,058.53
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,559,791,608.41	4,469,684,367.09
3	Нийт ашиг (алдагдал)	(249,732,562.79)	(373,016,308.56)
4	Түрээсийн орлого		818,181.82
5	Хүүний орлого	2,060,343.59	867,898.22

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

6	Бусад орлого	251,160,840.09	403,325,203.23
7	Ерөнхий ба удирдлагын зардал	155,565,502.13	119,986,477.99
8	Бусад зардал	154,133,805.70	130,721,117.03
9	Үнэгүй авсан үндсэн хөрөнгө		604,746,884.00
10	Үнэ төлбөргүй авсан бараа материал		6,138,000.00
11	Үнэдсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз		-30,780,796.93
12	Бусад ашиг /алдагдал/		
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(306,210,686.94)	361,391,466.76
14	Орлогын татварын зардал		
15	Татварын дараах ашиг (алдагдал)	(306,210,686.94)	361,391,466.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	(41,320,912.77)	5,259,360,033.12
3	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	(41,320,912.77)	5,259,360,033.12
11	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	(41,320,912.77)	5,259,360,033.12
13	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	(41,320,912.77)	5,259,360,033.12
19	Тайлант үеийн цэвэр ашиг				361,391,466.76	361,391,466.76
21	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	320,070,553.99	5,620,751,499.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	3,951,840,045.51	4,778,808,879.84
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	3,618,047,020.72	4,366,018,566.84
	Түрээсийн орлого		900,000.00
	Техникийн нөхцлийн орлого		71,216,000.00
	Тоолуурын орлого		19,778,600.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	333,793,024.79	320,895,713.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	4,124,543,230.80	4,633,142,118.61
	Ажилчдад төлсөн	1,229,879,356.04	1,588,038,080.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	413,283,898.65	505,150,736.88
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	974,618,693.30	816,469,490.89
	Ашиглалтын зардалд төлсөн	314,570,828.71	474,244,558.19
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	417,021,020.00	320,563,205.00
	Хүүний төлбөрт төлсөн		2,804,979.22
	Татварын байгууллагад төлсөн	378,494,634.44	420,332,839.57
	Бусад мөнгөн зарлага	396,674,799.66	505,538,228.86
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(172,703,185.29)	145,666,761.23

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	2,060,343.59	945,691.42
	Хүлээн авсан хүүний орлого	2,060,343.59	945,691.42
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн		225,938,374.42
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	234,402,482.41	225,938,374.42
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,060,343.59	(224,992,683.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	19,727,411.00
	Төрөл бүрийн хандив		19,727,411.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	49,640,274.88	66,780,510.98
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	41,640,274.88	66,780,510.98
	Бусад зарлага	8,000,000.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(49,640,274.88)	(47,053,099.98)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(220,283,116.58)	(126,379,021.75)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	459,757,622.55	239,474,505.97
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	239,474,505.97	113,095,484.22

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр усан хангамж	1,102,540,473.40	1,412,521,647.38	1,407,365,847.76	5,155,799.62	99.6
Ариутгах татуурга	741,828,615.01	1,172,193,116.91	1,195,828,746.95	-23,635,630.04	102.0
Дулаан хангамж	1,104,980,430.01	1,676,517,181.32	1,127,884,694.49	548,632,486.83	67.3
Суурь хураамж	177,630,600.00	188,454,300.00	191,775,303.64	-3,321,003.64	101.8
УТБ	154,614,931.00	160,439,822.60	159,828,273.64	611,548.96	99.6
Бусад	282,485,178.80	302,681,381.82	418,996,471.82	-116,315,090.00	138.4
Нийт борлуулалт	3,563,280,228.23	4,912,807,450.03	4,501,679,338.30	411,128,111.73	91.6
Цалин түүнтэй адилтгах зардал	1,719,322,709.43	2,355,764,068.01	2,363,550,993.80	-7,786,925.79	100.3
Цалин түүнтэй адилтгах зардал	1,480,437,739.00	2,070,525,509.91	2,079,659,159.80	-9,133,649.89	100.4
НДШ -АО	198,739,970.43	261,999,118.10	266,708,234.00	-4,709,115.90	101.8
ТУЗ цалин	35,760,000.00	20,880,000.00	15,500,000.00	5,380,000.00	74.2
ТУЗ НДШ	4,385,100.00	2,359,440.00	1,683,600.00	675,840.00	71.4
Нийгмийн хамгаалал ажиллагсадтай холбоотой зардал	124,848,640.00	215,135,035.20	208,963,674.00	6,171,361.20	97.1
Тэтгэмж	38,507,887.00	90,765,340.00	90,765,336.00	4.00	100.0
Шагнал урамшууллын зардал	7,194,232.00	11,640,000.00	13,711,233.00	-2,071,233.00	117.8
Баяр ёслол Ажилчдын нийгмийн арга хэмжээнд	14,198,350.00	25,520,000.00	25,686,427.00	-166,427.00	100.7
Сургалт	8,271,652.00	10,073,400.00	8,056,809.00	2,016,591.00	80.0

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Албан томилолтын зардал	13,374,400.00	15,495,984.20	15,495,981.00	3.20	100.0
Зочид хүлээн авах зардал	0.00	500,000.00	272,700.00	227,300.00	54.5
Ахмадын зардал	14,405,263.00	26,437,030.00	10,656,818.00	15,780,212.00	40.3
Ажилчдын хоолны зардал	27,896,856.00	35,203,281.00	44,318,370.00	-9,115,089.00	125.9
Татвар, төлбөр, хураамж, даатгал	96,893,444.00	106,184,356.00	104,440,242.40	1,744,113.60	98.4
Татварын зардал	37,551,676.00	38,000,000.00	39,624,720.40	-1,624,720.40	104.3
Даатгал	3,448,373.00	5,650,000.00	5,678,115.00	-28,115.00	100.5
Аудит	10,400,000.00	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл	16,178,871.00	24,733,100.00	24,733,099.00	1.00	100.0
Зээлийн хүүгийн зардал		600,000.00	317,706.00	282,294.00	53.0
Банкны шимтгэл хураамж	2,027,630.00	3,000,000.00	2,902,748.00	97,252.00	96.8
Түрээсийн зардал	7,309,862.00	7,526,300.00	949,750.00	6,576,550.00	12.6
Маркетинг борлуулалтын зардал	7,076,795.00	-	330,000.00	-330,000.00	
Ритус , ABIS ECM биллинг программын зардал, GPS-ийн зардал	12,843,657.00	22,174,956.00	22,916,832.00	-741,876.00	103.3
Алданги торгуулийн зардал	56,580.00	-	2,487,272.00	-2,487,272.00	
Ашиглалтын зардал	699,561,116.00	891,038,748.20	889,211,169.23	1,827,578.97	99.8
Эрчим хүч	274,540,623.00	430,125,080.00	430,558,725.00	- 433,645.00	100.1
Үндсэн хөрөнгийн элэгдэл	415,161,822.00	442,500,000.00	440,378,048.23	2,121,951.77	99.5
Харилцаа холбооны зардал	9,858,671.00	18,413,668.20	18,274,396.00	139,272.20	99.2
/материал/ сэлбэг хэрэгсэл	875,380,854.10	787,232,658.00	768,310,690.00	18,921,968.00	97.6
Түлш, халаалтын зардал	601,418,510.00	448,043,758.00	458,902,491.00	-10,858,733.00	102.4
Шатах тослох материал	112,557,815.00	114,500,000.00	111,374,733.00	3,125,267.00	97.3
сэлбэг хэрэгсэл /материал/	85,948,290.00	89,667,500.00	103,993,665.00	-14,326,165.00	116.0
Бичиг хэргийн зардал	16,465,423.10	9,853,000.00	9,198,004.00	654,996.00	93.4
Ариутгал, /шинжилгээ	6,795,045.00	8,500,000.00	9,119,981.00	-619,981.00	107.3
Хөдөлмөр хамгаалал, хангамжийн зардал	46,539,842.00	108,648,400.00	55,219,919.00	53,428,481.00	50.8
Хангамжийн зардал	0.00	10,550,000.00	12,849,902.00	- 2,299,902.00	121.8
Цэвэрлэгээний зардал	5,835,899.00	5,300,000.00	6,178,560.00	- 878,560.00	116.6
Гамшигийн эрсдэлээс хамгаалах зардал	0.00	200,000.00	157,190.00	42,810.00	78.6
Харуул хамгаалалтын зардал /Дотоодын цэрэг/	0.00	2,520,000.00	1,316,245.00	1,203,755.00	52.2

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Засвар үйлчилгээний зардал	348,550,934.00	357,373,981.00	411,110,781.00	-53,736,800.00	115.0
Засвар үйлчилгээний зардал- барилга байгууламж	146,652,737.00	23,850,000.00	36,238,270.00	-12,388,270.00	151.9
Засвар үйлчилгээний зардал - тоног төхөөрөмж		61,550,000.00	69,428,512.00	-7,878,512.00	112.8
Засвар үйлчилгээний зардал - шугам сүлжээний зардал		61,193,181.00	73,944,152.00	-12,750,971.00	120.8
бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	70,226,233.00	80,000,000.00	64,917,855.00	15,082,145.00	81.1
Үйл ажиллагааны бус зардал	131,671,964.00	100,000,000.00	135,801,196.00	-35,801,196.00	135.8
Хөрөнгө ақталж устгасны орлого		30,780,800.00	30,780,796.00	4.00	100.0
Нийт Борлуулалт	3,563,280,228.23	4,425,328,384.45	4,501,679,338.29	76,350,953.84	101.7
Нийт зардал	3,864,557,697.53	4,712,728,846.41	4,745,587,550.43	-32,858,704.02	100.7
Ашиг алдагдал	-301,277,469.29	- 287,400,461.96	-243,908,212.14	-43,492,249.82	84.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 869,824.3 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд НӨАТ-ын 5,585.2 мянган төгрөгийн өр төлбөрийг дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант онд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 604,746.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 6,138.0 мянган төгрөгийн бараа материал, нийт 610,884.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бус эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлэн бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх дэх “үнэн зөв байх”, НББОУС-20 Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл 22-28 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 193,372.5 мянган төгрөгөөр дутуу, зарлагыг 59,981.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 44,542.5 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 950.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 43,592.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 5,449.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 30,846.3 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 25,397.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд 2 албан хаагчид томилолтын зардалд 400.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-т “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардалд илүү олгосон 400.0 мянган төгрөгийг захирал, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Тайлант онд “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2 албан хаагчид 200.0 мянга, гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 5 албан хаагчид тус бүр 50.0 мянга нийт 250.0 мянга, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газарт 100.0 нийт 550.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 550.0 мянган төгрөгийг захирал, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тус байгууллагад 3 жил ба түүнээс дээш хугацаанд ажиллаж өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 6 албан хаагчид нэг удаагийн тэтгэмжид нийт 39,093.3 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т “Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид тэтгэмж олгохдоо өнгөрсөн жилүүдийн ажлын үр дүнтэй уялдуулан үндсэн цалингийн сүүлийн жилүүдийн дунджаас олгох, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

3.2.2. Томилолтын хуудаст томилолтоор ажилласан хугацааг бичээгүй байхад томилолтын тооцоог бодож 4 албан хаагчид 18 хоногийн томилолтын зардалд нийт 4,499.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-т “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын хуудсыг бүрэн бөглөж, томилолт олгох зөвшөөрөл олгосны үндсэн дээр томилолтын зардлыг олгодог байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад төлбөрийн акт, албан шаардлагад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгахгүй орхигдуулсан	1	5,585.2	1	5,585.2	-	-	1	5,585.2	-	-
Санхүүгийн тайланд хөрөнгийг буруу тусган илэрхийлсэн	1	610,884.9	-	-	1	610,884.9	1	610,884.9	-	-
Орлого зарлагыг зөрүүтэй илэрхийлсэн	1	253,354.2	-	-	1	253,354.2	1	253,354.2	-	-
Дүн	3	869,824.3	1	5,585.2	2	864,239.1	3	869,824.3	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Тайлант онд 2 албан хаагчид томилолтын зардалд 400.0 мянган төгрөгийг илүү, томилолтын хуудаст томилолтоор ажилласан хугацааг бичээгүй байхад томилолтын тооцоог бодож 4 албан хаагчид 18 хоногийн томилолтын зардалд нийт 4,499.2 мянга, нийт 4,899.2 мянган төгрөгийг олгосон байна.	1	400.0	1	400.0	-	-	-	-	-	-

“Чандмань- Баянхонгор” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Тайлант онд “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2 албан хаагчид 200.0 мянга, гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 5 албан хаагчид тус бүр 50.0 мянга нийт 250.0 мянга, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газарт 100.0 нийт 550.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	550.0	1	550.0						
Тус байгууллагад 3 жил ба түүнээс дээш хугацаанд ажиллаж өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 6 албан хаагчид нэг удаагийн тэтгэмжид нийт 39,093.3 мянган төгрөгийг олгосон байна.	1	39,093.3	-	-	1	39,093.3	-	-	-	-
Томилолтын хуудаст томилолтоор ажилласан хугацааг бичээгүй байхад томилолтын тооцоог бодож 4 албан хаагчид 18 хоногийн томилолтын зардалд нийт 4,499.2 мянган төгрөгийг олгосон байна.	1	4,499.2	-	-	1	4,499.2	-	-	-	-
Дүн	4	44,542.5	2	950.0	2	43,592.5	-	-	-	-

-----oO-----